



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/33/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Ч.Гантулга

Утас: 70373089 Цахим хаяг: gantulgachu@audit.gov.mn

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОШМӨ	Үйлдвэрийн ослоос шалтгаалсан мэргэжлийн өвчин
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 57

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн хөрөнгөөр 56,500.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг худалдан авч, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Байгууллагын төлөвлөсөн 80.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого 101.2 хувь буюу 13,797.3 мянган төгрөгөөр давсан нь барилгын техник хяналтын ажил нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 32 зорилтын 111 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас 91.3 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4525020191

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>133,042,105.80</u>	<u>272,184,817.65</u>
33	АВЛАГА	<u>79,697,622.80</u>	<u>235,988,457.40</u>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	79,697,622.80	234,988,457.40
33300	Татаас санхүүжилтийн авлага	-	1,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	<u>20,000,000.00</u>	-
34600	Урьдчилж гарсан зардал	20,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>33,344,483.00</u>	<u>36,196,360.25</u>
351	Түүхий эд материал	<u>598,000.00</u>	<u>598,000.00</u>
35110	Тусгай зориулалттай материал	598,000.00	598,000.00
354	Хангамжийн материал	<u>32,746,483.00</u>	<u>35,598,360.25</u>
35410	Бичиг хэргийн материал	4,855,789.00	6,470,749.00
35420	Аж ахуйн материал	18,123,650.00	18,123,650.00
35430	Сэлбэг хэрэгсэл	9,027,044.00	9,027,044.00
35440	Түлш, шатах тослох материал	740,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	-	1,976,917.25
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>514,620,655.09</u>	<u>579,190,100.28</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>514,620,655.09</u>	<u>579,190,100.28</u>
392	Биет хөрөнгө	<u>299,491,954.91</u>	<u>347,943,666.74</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	271,513,749.56	271,513,749.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,105,122.00)	(44,526,146.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	56,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	212,825,169.54	224,774,969.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	(171,607,519.89)	(182,112,249.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,364,480.00	27,364,480.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,546,246.54)	(26,741,886.50)
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,430,913.84	32,430,913.84
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,383,469.60)	(11,260,163.52)
393	Биет бус хөрөнгө	<u>215,128,700.18</u>	<u>231,246,433.54</u>
39301	Программ хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(880,000.00)	(880,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	241,334,000.00	261,334,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(26,205,299.82)	(30,087,566.46)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>647,662,760.89</u>	<u>851,374,917.93</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>647,662,760.89</u>	<u>851,374,917.93</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>647,662,760.89</u>	<u>851,374,917.93</u>
511	Засгийн газрын оруулсан капитал	414,411,421.92	414,411,421.92
51101	Өмч: - төрийн	414,411,421.92	414,411,421.92
512	Хуримтлагдсан үр дүн	<u>129,630,043.24</u>	<u>333,342,200.28</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	26,065,020.43	129,630,043.24
51220	Тайлант үеийн үр дүн	103,565,022.81	203,712,157.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	103,621,295.73	103,621,295.73
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>647,662,760.89</u>	<u>851,374,917.93</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	872,319,674.99	1,180,460,767.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	110,060,589.99	261,037,950.40
120	Нийтлэг татварын бус орлого	110,060,589.99	261,037,950.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	110,060,589.99	261,037,950.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	107,565,618.66	249,088,150.40
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,494,971.33	11,949,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	762,259,085.00	919,422,817.25
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	680,768,900.00	793,832,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	680,768,900.00	793,832,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	79,263,685.00	124,539,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	38,100,000.00	124,539,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,163,685.00	-
1330	Төсвийн захирагчдаас	2,226,500.00	1,051,417.25
133003	Хөрөнгийн	2,226,500.00	1,051,417.25
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	768,754,652.18	976,748,610.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	768,754,652.18	976,748,610.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	558,274,440.77	848,902,148.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432,866,178.76	689,866,288.04
210101	Үндсэн цалин	257,524,464.00	331,007,802.11
210102	Нэмэгдэл	108,259,739.76	282,847,558.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,512,000.00	46,156,549.79
210104	Урамшуулал	45,569,975.00	29,717,795.09
210105	Гэрээт цалин	-	136,582.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,747,763.57	91,091,071.45
210201	Тэтгэврийн даатгал	38,686,166.81	67,648,973.19
210202	Тэтгэмжийн даатгал	4,396,161.62	5,785,293.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,415,664.48	2,775,855.94
210204	Ажилгүйдлийн даатгал	840,886.96	2,937,419.56
210205	Эрүүл мэндийн даатгал	8,408,883.70	11,946,529.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,830,333.57	9,552,973.47
210301	Гэрэл, цахилгаан	3,183,650.52	3,182,522.53
210302	Түлш, халаалт	3,667,410.56	4,551,522.38
210303	Цэвэр, бохир ус	979,272.49	1,818,928.56
2104	Хангамж, бараа материалын зардал	10,882,586.23	12,298,540.00
210401	Бичиг хэрэг	5,987,380.00	8,094,340.00
210402	Тээвэр, шатахуун	2,315,000.00	4,121,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	173,107.23	236,030.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,093,499.00	533,000.00
210408	Бараа материал акталсны зардал	1,313,600.00	-

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	260,700.00	-
210604	Урсгал засвар	260,700.00	-
2107	Томилолт, зочны зардал	852,000.00	634,000.00
210702	Дотоод албан томилолт	852,000.00	634,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,888,210.00	7,934,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,249,810.00	7,830,020.00
210803	Даатгалын үйлчилгээ	31,700.00	-
210807	Газрын төлбөр	106,700.00	104,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,946,668.64	37,524,555.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,602,676.32	13,644,201.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,343,992.32	23,880,354.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,480,211.41	127,846,461.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,278,000.00	54,298,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,910,000.00	2,680,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,368,000.00	-
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	51,618,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	166,202,211.41	73,547,661.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	164,383,744.42	73,547,661.84
	Хөрөнгийн	1,818,466.99	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>103,565,022.81</u>	<u>203,712,157.04</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>103,565,022.81</u>	<u>203,712,157.04</u>




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>787,900,580.86</u>	<u>1,012,168,715.80</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,867,995.86	93,797,315.80
120	Нийтлэг татварын бус орлого	27,867,995.86	93,797,315.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,867,995.86	93,797,315.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,867,995.86	93,797,315.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	760,032,585.00	918,371,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	680,768,900.00	793,832,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	680,768,900.00	793,832,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	79,263,685.00	124,539,000.00
	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	38,100,000.00	124,539,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,163,685.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>765,385,330.86</u>	<u>955,668,715.80</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	765,385,330.86	955,668,715.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	554,905,119.45	826,822,253.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	433,006,835.57	689,143,146.02
210101	Үндсэн цалин	234,840,432.91	331,007,802.11
210102	Нэмэгдэл	131,548,297.57	282,124,416.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,288,000.00	46,156,549.79
210104	Урамшуулал	43,330,105.09	29,717,795.09
210105	Гэрээт ажлын хөлс	-	136,582.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,607,106.76	91,814,213.47
210201	Тэтгэврийн даатгал	38,686,166.81	68,166,539.19
210202	Тэтгэмжийн даатгал	4,312,877.62	5,987,869.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,358,291.67	3,047,199.33
210204	Ажилгүйдлийн даатгал	840,886.96	2,881,734.77
210205	Эрүүл мэндийн даатгал	8,408,883.70	11,730,870.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,830,333.57	9,552,973.47
210301	Гэрэл, цахилгаан	3,183,650.52	3,122,722.53
210302	Түлш, халаалт	3,667,410.56	4,611,322.38
210303	Цэвэр, бохир ус	979,272.49	1,818,928.56
2104	Хангамж, бараа материалын зардал	3,103,907.23	2,913,140.00
210401	Бичиг хэрэг	421,600.00	385,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,100,000.00	1,990,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	235,807.23	236,030.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	346,500.00	301,350.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	260,700.00	333,400.00
210604	Урсгал засвар	260,700.00	333,400.00
2107	Томилолт, зочны зардал	852,000.00	634,000.00
210702	Дотоод албан томилолт	852,000.00	634,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,508,210.00	7,934,720.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,369,810.00	7,830,020.00
210803	Даатгалын үйлчилгээ	31,700.00	-
210807	Газрын төлбөр	106,700.00	104,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,736,026.32	24,496,661.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,736,026.32	24,496,661.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,480,211.41	128,846,461.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,278,000.00	54,298,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,910,000.00	2,680,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,368,000.00	-
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	51,618,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	166,202,211.41	74,547,661.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	164,383,744.42	73,327,348.48
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,818,466.99	1,220,313.36
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,818,466.99	1,220,313.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>22,515,250.00</u>	<u>56,500,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,515,250.00	56,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,515,250.00	56,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,515,250.00	56,500,000.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	22,515,250.00	56,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(22,515,250.00)</u>	<u>(56,500,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	414,411,421.92	103,621,295.73	26,065,020.43	544,097,738.08
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	414,411,421.92	103,621,295.73	26,065,020.43	544,097,738.08
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	103,565,022.81	103,565,022.81
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	414,411,421.92	103,621,295.73	129,630,043.24	647,662,760.89
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	414,411,421.92	103,621,295.73	129,630,043.24	647,662,760.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	414,411,421.92	103,778,552.76	129,630,043.24	647,662,760.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	203,712,157.04	203,712,157.04
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	414,411,421.92	103,778,552.76	333,342,200.28	851,374,917.93




2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	873,832,400.00	814,302,367.32	(59,530,032.68)	93.2
21	Урсгал зардал	873,832,400.00	814,302,367.32	(59,530,032.68)	93.2
210	Бараа ажил үйлчилгээний зардал	819,293,100.00	760,003,567.32	(59,289,532.68)	92.8
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	632,658,800.00	580,694,990.06	(51,963,809.94)	91.8
210101	Үндсэн цалин	257,143,200.00	330,528,958.94	73,385,758.94	128.5
210102	Нэмэгдэл	320,398,000.00	174,360,486.87	(146,037,513.13)	54.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,006,200.00	46,121,894.74	17,115,694.74	159.0
210104	Урамшуулал	26,111,400.00	29,683,649.51	3,572,249.51	113.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,220,500.00	76,943,682.79	(5,276,817.21)	93.58
210201	Нийгмийн даатгал	51,749,900.00	55,392,846.67	3,642,946.67	107.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,617,700.00	5,467,097.71	(2,150,602.29)	71.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,808,800.00	2,773,057.71	(1,035,742.29)	72.8
210204	Ажилгүйдлийн даатгал	3,808,800.00	2,621,348.94	(1,187,451.06)	68.8
210205	Эрүүл мэндийн даатгал	15,235,300.00	10,689,331.76	(4,545,968.24)	70.2
2103	Байр ашиглалттай холбоото тогтмол зардал	9,614,800.00	9,552,973.47	(61,826.53)	99.4
210301	Гэрэл, цахилгаан	3,981,600.00	3,122,722.53	(858,877.47)	78.4
210302	Түлш, халаалт	4,887,000.00	4,611,322.38	(275,677.62)	94.4
210303	Цэвэр, бохир ус	746,200.00	1,818,928.56	1,072,728.56	243.8
2104	Хангамж, бараа материалын зардал	3,611,500.00	2,899,940.00	(711,560.00)	80.3
210401	Бичиг хэрэг	439,000.00	385,000.00	(54,000.00)	87.7
210402	Тээвэр, шатахуун	2,488,900.00	1,990,760.00	(498,140.00)	79.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	241,600.00	222,830.00	(18,770.00)	92.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	442,000.00	301,350.00	(140,650.00)	68.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	336,100.00	333,400.00	(2,700.00)	99.2
210604	Урсгал засвар	336,100.00	333,400.00	(2,700.00)	99.2
2107	Томилолт, зочны зардал	1,148,700.00	634,000.00	(514,700.00)	55.2
210702	Дотоод албан томилолт	1,148,700.00	634,000.00	(514,700.00)	55.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн	8,604,900.00	7,934,720.00	(670,180.00)	92.2



	ажил, үйлчилгээний төлбөр хураамж				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,341,800.00	7,830,020.00	(511,780.00)	93.9
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	127,300.00	-	(127,300.00)	-
210803	Даатгалын Үйлчилгээ	31,100.00	-	(31,100.00)	-
210807	Газрын төлбөр	104,700.00	104,700.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81097800.00	81009861.00	(87,939.00)	99.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,097,800.00	81,009,861.00	(87,939.00)	99.89
213	Урсгал шилжүүлэг	54,539,300.00	54,298,800.00	(240,500.00)	99.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,539,300.00	54,298,800.00	(240,500.00)	99.56
21320	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж	2,920,500.00	2,680,000.00	(240,500.00)	91.8
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	51,618,800.00	51,618,800.00	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	873,832,400.00	828,099,683.12	(45,732,716.88)	93.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	793,832,400.00	734,302,367.32	(59,530,032.68)	92.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	793,832,400.00	734,302,367.32	(59,530,032.68)	92.5
132	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	80,000,000.00	93,797,315.80	13,797,315.80	101.6
132001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,000,000.00	93,797,400.00	13,797,315.80	101.6
	Байгууллагын тоо	1	1	-	100.0
	Ажиллагсдын тоо	27	24	(3)	88.9
	Удирдах ажилтан	1	1	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	22	20	(2)	90.9
	Үйлчлэх ажилтан	4	2	(2)	50.0
	Гэрээт ажилтан	-	1	1	-



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	123,318,686.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	123,318,686.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	123,318,686.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл, урамшуулал	108,448,155.96
210101	Үндсэн цалин	478,843.17
210102	Нэмэгдэл	107,763,929.83
210103	Унаа, хоол	34,655.05
210104	Урамшуулал	34,145.58
210105	Гэрээт ажлын хөлс	136,582.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,870,530.68
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	14,870,530.68
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	124,539,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	124,539,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,539,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь эд хөрөнгө өмчлөх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрх, газрын харилцааг зохицуулах үйл ажиллагааны байгууллага юм. Тус байгууллага Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, аймгийн засаг даргын болон Засгийн газрын агентлагийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах төрийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй, шуурхай иргэдэд хүргэх зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Кадастр, геодезийн тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Газар өмчлөлийн тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 203,711.9 мянган төгрөгөөр буюу 131 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-

Авлага	79,697.6	235,988.4	156,290.8
УТЗардал	20,000.0	-	(20,000.0)
Бараа материал	33,344.5	36,196.2	2,851.7
Үндсэн хөрөнгө	514,620.6	579,190.1	64,569.5
Нийт хөрөнгө	647,662.8	851,374.7	203,711.9
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	647,662.8	851,374.7	203,711.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	647,662.8	851,374.7	203,711.9

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд авлага 156,290.8 мянган төгрөгөөр өссөн нь Барилгын хөгжлийн төвөөс барилгын техник хяналтын зардлын төлбөр төлөгдөөгүйгээс шалтгаалжээ.

Урьдчилж төлсөн зардал 20,000.0 мянган төгрөгөөр буурсан нь гэрээгээр гүйцэтгэх зураг төслийн ажил бүрэн хийгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн хөрөнгөөр 11,872.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, Газар зохион байгуулалт, геодези, зураг зохион байгуулалтын газраас 984.2 мянган төгрөгийн бараа материал шилжин ирсэн, 10,004.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан зэрэг нь материалын дансны үлдэгдлийн өсөлтөд нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 64,569.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 76,500.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, хандиваар 2,002.4 мянган төгрөгийн, аймгийн ИТХ-ын 2024 оны 26 дугаар тогтоолоор 9,947.4 мянган төгрөгийн компьютер техник хангамжийг хүлээн авч, 23,880.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 797,332.4 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөн, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг 39,755.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 837,088.0 мянган төгрөгөөр баталжээ. Энэ нь цалин хөлс, НДШ-ийн зардлыг 288,012.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, байр ашиглалтын зардлыг 537.6 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 26,557.7 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 5,200.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 144,391.1 мянган төгрөгөөр, томилт, зочны зардлыг 25,891.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 20,176.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 18,902.2 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 6,600.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 36,744.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 873,832.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь батлагдсан орон тоо дутуугаас цалингийн зардлын санхүүжилтийг 75,646.2 мянган төгрөгөөр бууруулж, байгууллагын орчны цэвэрлэгээг сайжруулах гэрээт үйлчлэгчийн цалинг 7,851.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 50,000.0 мянган төгрөгөөр, хөдөө ОН-т тогтвор суурьшилтай

ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийг 54,539.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэх 873,832.4 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тодотгон баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 793,832.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанаас 93,797.3 мянган төгрөгийн орлого олж, урсгал үйл ажиллагаанд 814,302.3 мянган төгрөгийг зарцуулж, урсгал санхүүжилтээс 59,530.0 мянган төгрөг, давсан орлогоос 13,797.3 мянган төгрөг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь дутуу орон тоогоор ажилласнаас цалингийн зардлаас 57,239.5 мянган төгрөгийг зарцуулаагүй, бараа үйлчилгээний зардлыг 16,087.8 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 814,302.3 мянган төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь орон тоо дутуугаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг 57,240.6 мянган төгрөг, байр ашиглалтын зардлыг 61.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 711.6 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 2.7 мянган төгрөг, томилолтын зардлыг 514.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 670.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 87.9 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 240.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 857,923.4 мянган төгрөг буюу 93.2 хувьтай гарсан нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	71504- Газрын зураглал, кадастр	873,832.4	814,302.3	(59,530.1)	93.2
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	761,441.8	702,177.3	(59,264.5)	92.2
2	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж	54,539.3	54,298.8	(240.5)	99.6
3	80226- Байр ашиглалтын зардал	7,851.3	7,830.0	(21.3)	99.7
4	82404- Барилгын техник хяналтын зардал	50,000.0	49,996.2	(3.8)	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 124,539.0 мянган төгрөг төвлөрснөөс 123,318.7 мянган төгрөгийг орон нутгийн нэмэгдэл цалинд зарцуулж, үлдэгдэл 1,220.3 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын аудитор Ч.Гантулга гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 38 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 983,742.6 мянган төгрөгөөс алдаа, зөрчил илрэх магадлалыг дунд гэж үзээд 1.0 хувиар буюу 9,837.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д заасны дагуу бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардлыг 8,521.5 мянган төгрөгөөр, 15.2.7-д заасны дагуу бараа үйлчилгээний бусад зардлыг 80,601.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 2,478,295.6 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтуудтай нийцэхгүй байгаа тул Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж байх, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны цахим нэгдсэн хуудаст байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан ба нийт 2,850.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн бөгөөд ТШЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 31-ний өдрийн 349 тоот албан бичгээр ирүүлсэн биелэлтийг тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад 100 хувь хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	2,850.6	1	2,850.6	100.0
Нийт дүн	1	2,850.6	1	2,850.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар албан хаагчдад олгосон үр дүнгийн урамшууллын тооцооллыг анхаарч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 100,303.6 мянган төгрөгийн алдаа¹ ирлүүлж аудитын явцад залруулав.
Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүн, үр дүнгийн тайлан дахь дүнгээс 67,133.6 мянган төгрөгийн зөрүүтэй алдаа нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн тодруулга”, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланд залруулав,
2. Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалт 20,000.0 мянган төгрөг, үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 2,002.3 мянган төгрөгийг дутуу илэрхийлсэн алдаа нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн тодруулга”, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланд залруулав,
3. Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн орлогын үзүүлэлтэд 1,220.3 мянган төгрөгийг хасах дүнтэй илэрхийлсэн, алдаа нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн тодруулга”, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланд залруулав,
4. Аймгийн ИТХ-ын 2024 оны 26 дугаар тогтоолоор хүлээн авсан 9,947.4 мянган төгрөгийн 6 төрлийн компьютер техник хангамжийг нягтлан бодох бүртгэл болон үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй нь НББ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсэг, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх” зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дансанд тусгаж залруулав.

Мөн аудитаар нийт 566.5 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

Барилгын лабораторийн шинжээч С.Дарханбаатарт тушаалаар заасан хувь хэмжээг хэтрүүлэн 566,548.00 төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтын 2, Газрын харилцаа, барилга холт байгуулалтын газрын даргын 2024 оны “Ур чадварын нэмэгдэл олгох тухай” Б/05 дугаар тушаалтай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлантай холбоотой зөвлөмж өгөөгүй болно.

Тайлангийн 4.4.1 дэх хэсэгт дурдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусгаан илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүн, үр дүнгийн тайлангийн үр дүнгээс дутуу	1	67,133.6	-	-	-	-	1	67,133.6	-	-	-	-
Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийг Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалт, үр дүнгийн тайлангийн орлогын үзүүлэлтэд дутуу илэрхийлэгдсэн	1	22,002.3	-	-	-	-	1	22,002.3	-	-	-	-
Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн орлогын дүнд төвлөрүүлэх шилжүүлэг гэсэн хасах дүнтэй илэрхийлэгдсэн	1	1,220.3	-	-	-	-	1	1,220.3	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэл, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд шилжиж ирсэн хөрөнгийг бүртгээгүй	1	9,947.4	-	-	-	-	1	9,947.4	-	-	-	-
Дүн	3	100,303.6	-	-	-	-	3	100,303.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын даргын тушаалаар заасан хувь хэмжээг хэтрүүлэн үр чадварын нэмэгдлийг илүү тооцож олгосон	1	566.5	1	566.5	-	-	-	-	-	-	-	-
Дүн	1	566.5	1	566.5	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	1	2,478,295.6	-	-	-	-	1	2,478,295.6
Дүн	1	2,478,295.6	-	-	-	-	1	2,478,295.6